Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл

Ажлын хэсгийн хуралдаан 2009 оны 6 дүгээр сарын 5-ны өдрийн 17.00 цагт Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн хурлын танхимд эхлэв.

Ажлын хэсгийн хуралдаанд Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч Б. Эрдэнэсүрэн, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга, ажлын хэсгий гишүүн н.Мягмардаш, Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н. Алгаа, Миний Монголын Газар шороо Хөдөлгөөний гүйцэтгэх захирал, ажлын хэсгийн гишүүн Б.Болдбаатар, Монголын үйлдвэрлэгчдийн холбооны тэргүүн, ажлын хэсгийн гишүүн Н.Дашзэвэг, Инфорум төвийн тэргүүн, ажлын хэсгийн гишүүн Р.Батпүрэв, Засгийн газрын ахлах референт, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумъяа, Ил тод сангийн тэргүүн, ажлын хэсгийн гишүүн н.Цэрэнжав, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Уул уурхай, хүнд үйлдвэрийн газрын дарга, ажлын хэсгийн гишүүн н.Батхүүг орлож мэргэжилтэн н.Хүрэлбат, Монросцветмет ХХК-ийн гүйцэтгэх захирал, ажлын хэсгийн гишүүн Д.Эрдэнээг орлож газрын дарга н.Галсандорж, Бороо гоулд ХХК-ийн гүйцэтгэх захирал, ажлын хэсгийн гишүүн Ж. Казаковыг орлож ня-бо н.Мөнхдорж, Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн гүйцэтгэх захирал, ажлын хэсгийн гишүүн С.Мэргэнсодыг орлож Ерөнхийлөгчийн зөвлөх А.Эрдэнэдорж, Нүүрс ассоциацийн тэргүүн, ажлын хэсгийн гишүүн Л.Даваацэдэвийг орлож мэргэжилтэн Сарангэрэл, Нээлттэй нийгэм форумын менежер, ажлын хэсгийн гишүүн Н. Дорждарийг орлож тус форумын Төлсөн авснаа нийтэл хөтөлбөрийн зохицуулагч Д.Сэнгэлмаа, ОҮИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмон, санхүүгийн ажилтан Т. Хүрэлчимэг нар оролцов. Хуралдаанд Эрнст энд Янг Монголиа Аудит компаний менежер Питер Вонг, аудитор Б. Батзаяа, Л. Оюу-Эрдэнэ нар асуудал танилцуулахаар оролцов. Хуралд ажлын хэсгийн 25 гишүүн оролцох ёстой байсан боловч 15 гишүүн оролцож ирц 60 хувьтай байлаа.

Ажлын хэсгийн хуралдааныг Ажлын хэсгийн ахлагч Б. Эрдэнэсүрэн нээв.

Б. Эрдэнэсүрэн: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Өнөөдрийн ажлын хэсгийн хуралдаанаар дараахь асуудлуудыг хэлэлцэнэ:

1. Монголын Олборлох үйлдвэрлэлийн Ил тод байдлын Санаачлагын 2007 оны нэгдсэн тайлангийн явц- 10 минут
   -Малайз, Монголын Эрнст Янг аудитын компаниудын консорциумын аудитор Г. Алтансүх
   -Асуулт хариулт
2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2008 оны тайлан гаргах ажлын явц- 10 минут
   -Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмон
   -Асуулт хариулт
3. Олборлох үйлдвэрлэлийн Ил тод байдлын олон улсын Баталгаажуулалтад бэлтгэх ажлын төлөвлөгөөг батлах тухай- 15 минут
   -Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмон
   -Асуулт хариулт

Хэлэлцэх асуудлаар гишүүд саналаа солилцох, төслийг батлах, дэмжих болно. Хэлэлцэх асуудлаар санал гараагүй болно. Дээрх асуудлыг хэлэлцэхээр тогтов.

Б.Эрдэнэсүрэн-Эхний асуудлыг хэлэлцэхэд байх шаардлагатай зарим нэг гишүүн ирж яваа тул түүнийг иртэл 2 дугаар асуудлаа эхэлж хэлэлцэе.

I. Хэлэлцсэн нь: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2008 оны тайлан гаргалтын явцын талаархи танилцуулга

Энэ асуудлыг Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмон танилцуулна.

Ш.Цолмон: Ажлын хэсгийн 2009 оны 4 дүгээр сарын 9-ны өдрийн хуралдаанаас хойш тайлан гаргах чиглэлээр компаниудад зориулсан сургалт 2 удаа зохион байгууллаа. ОҮИТБС-ийн 2008 оны тайлан гаргах ажлын явцын талаар танилцуулга хийж тайлан гаргасан 67 компанийг нэрээр үзүүлэв. Ер нь тайлан гаргасан байвал зохих 113 компаниудын нэрийг ч харуулав. Засгийн газрын тайлан гаргалтын явц удаан байгаа талаар онцлон тэмдэглэж, энэ чиглэлээр Татварын ерөнхий газрын дарга Ц.Оюунбаатар, Сангийн яамны газрын дарга Мягмардаш нартай уулзаж, байнга ярьж байгаа тухай Ш.Цолмон онцлон тэмдэглэв. (Дэлгэрэнгүй танилцуулгыг хавсаргав.)

Б.Эрдэнэсүрэн: 67 компани тайлан гаргасан гэдэг ч бас гайгүй тоо байна. Хувийн байгууллага нь гаргачихаад байхад төрийн байгууллага нь гаргахгүй байна гэж юу гэсэн үг вэ? Засгийн газрын тайланг гаргуулах тал дээр Ажлын алба анхаарч ажилла. Бүүр болохгүй бол сайд, ер нь Ерөнхий сайдын гарын үсэгтэй бичиг ч явуулж, шахаж шаардаж болно шүү дээ.

Ш.Цолмон: Бид Ажлын албанаас аймгуудын Засаг дарга нарт албан бичиг явуулсан.

Н.Дашзэвэг: Компаниудын тайланг татвараас шууд авч болдоггүй юм уу?

П.Батпүрэв-Манай санаачлагын зорилго тайлан гаргаад орхих биш, харин нийтэд мэдээлэх, зарлахдаа байгаа шүү дээ.

Ш.Цолмон: Н.Дашзэвэгийн асуултын талаар ярьдаг юм. Яг бодит ажил болсон юм алга байна. Бас зарим компаниуд бид хайгуул хийдэг, олборлолт хийдэггүй ээ гээд тайлангаа гаргахгүй байгаа тал байна.

Б.Эрдэнэсүрэн-Хайгуулын компани тайлан гаргахгүй нь зөв биш юм үү.

Алгаа-Хайгуулын компани тусгай зөвшөөрлийн төлбөр, газрын төлбөр төлж байгаа.

П.Батпүрэв-Олборлолт явуулахгүй хайгуул хийж байгаа ч гэсэн хүмүүс их сонирхож байдаг юм.

н.Тэнгис: Тайлангийн маягт нь болохгүй байгаа юм биш үү. Тэгвэл олборлох компаниудаасаа салгаад хайгуулын компаниудад зориулсан тусдаа маягттай байвал болох юм.

Ш.Цолмон: Энэ зөв зүйтэй санаа байна.

Алгаа-хайгуулд их хөрөнгө зардаг. Хайгуул хийдэг компаниудыг тусгай маягтаар тайлан гаргуулж болно.

Н.Дашзэвэг-жижиг аж ахуйн нэгжүүдийг хасч тайланг том аж ахуйн нэгжүүдээр гаргуулж байх зөв юм.

Б.Эрдэнэсүрэн-Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй компаниас олон нийтийн анхаарал татаж байгаа аж ахуйн нэгжийн тайланг гаргуулж нийтэд мэдээлэх нь зөв.

П.Батпүрэв-Хайгуулын жижиг аж ахуйн нэгжийн тайланг орон нутгийн салбар ажлын хэсгийн анхаарал байлгаж тайланг гаргуулж нийтэд мэдээлж байж бас болно.

Б.Эрдэнэсүрэн-Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2008 оны тайлан гаргалтын явцыг хэлэлцлээ. Тайлан гаргалтын явц 2007 оны тайлан гаргалтын түвшинд байгаа юм байна. Хэлэлцсэн асуудлаар дараахь шийдвэр гаргая.

Шийдвэрлэсэн нь: 1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2008 оны тайлан гаргаагүй компаниудын тайланг гаргуулах арга хэмжээ авахыг Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонд даалгав. Тайлангаа гаргахгүй байгаа компанийг бидэнд мэдэгдэж байх, нийтэд мэдээлэх арга хэмжээ авч байх хэрэгтэй.

2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын Засгийн газрын 2008 оны тайланг энэ оны 7 дугаар сарын 5-ны дотор гаргаж дуусган нийтэд мэдээлж, ажлын албанд ирүүлэхийг Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын дарга, ажлын хэсгийн гишүүн С.Мягмардаш, Татварын ерөнхий газрын дарга, ажлын хэсгийн гишүүн Ц.Оюунбаатар нарт даалгав.

Б.Эрдэнэсүрэн: За дараагийн асуудалдаа оръё.

II. Хэлэлцсэн нь: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын олон улсын баталгаажуулалтад бэлтгэх ажлын төлөвлөгөөний төсөл

Төлөвлөгөөний төслийг ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулав (Төлөвлөгөөний төслийг хавсаргав) Мөн баталгаажуулалтад бэлтгэх үнэлгээний хороо байгуулах тухай танилцуулав (Үнэлгээний хорооны талаархи танилцуулгыг хавсаргав).

Б.Эрдэнэсүрэн: Төлөвлөгөөнд УИХ-ын байнгын хороонд 7 дугаар сард танилцуулна гэсэн байна. Энэ яасан ч амжихгүй дээ. Харин баталгаажуулалтаа хийсний дараа намрын чуулган дээр 12 сард танилцуулна гээд оруулчихсан нь дээр байх.

Ш.Цолмон: За үүнийг тэгвэл өөрчилье. Баталгаажуулалтанд бэлдэх бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Н.Дашзэвэг: Энэ үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд чинь хүн нэмж оруулах бололцоо байна уу? Намайг оруулчих.

Ш.Цолмон: За тэгье.

Б. Эрдэнэсүрэн: За өөр санал байхгүй бол дараахь шийдвэр гаргая.

Шийдвэрлэсэн нь: 1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын олон улсын баталгаажуулалтад бэлтгэх ажлын төлөвлөгөөг дэмжиж, төлөвлөгөөг нийтэд мэдээлэх, хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонд үүрэг болгов.

2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын олон улсын баталгаажуулалтад бэлтгэх ажлын төлөвлөгөөг орчуулж Олборлох үйлдвэрлэлийн

ил тод байдлын санаачлагын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлэхийг Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонд даалгав.

3. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын олон улсын баталгаажуулалтад бэлтгэх үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд Монголын үйлдвэрлэгчдийн холбооны тэргүүн, ажлын хэсгийн гишүүн Н.Дашзэвэгийг нэмж оруулж батлахаар тогтов. Үнэлгээний хорооны үйл ажиллагааг төлөвлөн өдөр дутмын дэмжлэгээр хангаж ажиллах, ажлын явцын талаар удирдлагад болон нийтэд мэдээлж байхыг Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонд үүрэг болгов.

4. Ажлын хэсэг, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газартай хамтран энэ оны 7 дугаар сарын 8-ны өдөр хамтарсан сургалт-семинар зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж, энэ ажлыг зохион байгуулахыг Ажлын албанд зөвшөөрөв.

Б.Эрдэнэсүрэн- дараагийн асуудалдаа оръё.

III. Хэлэлцсэн нь: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2007 оны тайланд Эрнст энд Янг Монголиа Аудит компанийн хийж байгаа аудитын талаар мэдээлэл

Питер: Бид Эрнст энд Янг Монголиа Аудит компанийг төлөөлөн оролцож байна. Намайг Питер Вонг гэдэг, тус компаний Монгол дахь салбарын менежер ажилтай, өнөөдөр энд надаас гадна аудитор Б.Батзаяа, Л.Оюу-Эрдэнэ гэсэн манай 2 аудитор ирсэн байна. Бид улсад төлсөн татвар төлбөрийн хэмжээ нь бусдаасаа өндөр буюу 200 сая төгрөгөөс дээш, 2 талдаа тайлантай 38 компаний тайланд аудит хийж байгаа. Гэрээнд заасан ажлын 1 дүгээр үед буюу одоогийн байдлаар:

- тайлангуудын зөрүүг гаргасан;
- зарим компани, төрийн байгууллагууд дээр эдгээр зөрүүг тодруулах анхан шатны уулзалтуудыг хийсэн;
- Мөн компани, байгууллага болгонд зөрүү тус бүрийн тодруулгыг хүссэн албан бичиг явуулсан нь эхнээсээ хариу тодруулгууд ирж байна.

Бидний цуглуулсан мэдээллээр гарсан зөрүү та бүхэнд тараасан тайлангийн хавсралт D дээр байгаа. Нийт зөрүү 55 тэрбум төгрөг болж байна. Тайлангийн үндсэн зөрүү 23.4 тэрбум төгрөг байна.

Ш.Цолмон: Энд би нэг зүйл тайлбарлая. Нэмэгдсэн өртгийн албан татвар, хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл гэх мэт татвар, хураамжууд тайлангийн маягт дээр байхгүй байгаа. Эдгээрийг оруулахгүй гэж тохирсон боловч зөрүүнд энэ тоог аудиторууд яагаад оруулчихсан байгааг ойлгохгүй байна. Тэгэхээр энэ зөрүү 55 тэрбум гэдэг бол их өндөр бас худлаа дүн болж харагдаж байна.

Питер: Бид та бүхэнд зөвхөн эхний байдлаар л гаргасан мэдээллийг танилцуулж байна. Тиймээс та бүхний саналыг тусгаж үндсэн тайлангаа гаргана.

Н.Дашзэвэг: Тэр нэмэгдсэн өртгийн албан татвар энэ тэрийг чинь уул нь харуулж байвал л зүгээр юм биш үү.

Ш.Цолмон: Нэмэгдсэн өртгийн албан татвар бидний өмнөх тайлангийн маягтад байсныг нь тайлан будилуулж байна, ач холбогдол муутай зүйл гэж хасчихаад дахиад оруулах нь утгагүй юм. 2008 оны 1 дүгээр сард ОҮИТБС- ын анхны тайланг хэлэлцээд, олон улсын болон аудиторын зөвлөмжүүдийг сонсоод Нэмэгдсэн өртгийн албан татварыг хасах шийдвэрийг Үндэсний зөвлөлөөс гаргасан юм.

Тайландаа Нэмэгдсэн өртгийн албан татвараа тавьсан 3 компани байгаа, нөгөө манай аудиторууд нэмэгдсэн өртгийн албан татвараа оруулсан компаниудаас тодруулга хийхийг хүсээгүй байж үүнийг оруулах нь буруу юм.

Н.Дашзэвэг: За тэгвэл үүнийгээ хасчих даа.

Питер: За та бүхний саналыг хүлээж авлаа.

Р.Батпүрэв: Та бүхний явуулсан захианд компаниуд болон төрийн байгууллагууд хариу тодруулгаа өгч байна уу? Явц нь ямар байна?

Питер: Бид 2 долоо хоногийн хугацаан дотор тодруулгаа өгөөч гэсэн байгаа. Одоогийн байдлаар цөөн хэдэн компаниуд тодруулгаа ирүүлсэн, ихэнх нь ирүүлээгүй байна.

Ш.Цолмон: Одоогийн байдлаар 5 компани тодруулгаа ирүүлсэн байна.

Б.Эрдэнэсүрэн: Түрүү жилийн аудитын тайлантай харьцуулахад танай ажил ямаршуухан болж байна гэж өөрсдөө дүгнэж байна вэ?

Питер: Ер нь бидний ажиллаж байгаа арга барил бусдаас өөр учир, яг харьцуулаад, шууд дүгнээд хэлчихэд хэцүү байна. Бид манай энэ төслийг хариуцсан менежер хатагтай Оливиятай энэ талаар харьцуулалт хийсэн дүгнэлт гаргах талаар ярья.

Б.Эрдэнэсүрэн: Энэ аудиторуудад гишүүдээс хэлэх санал байна уу?

Э.Сумъяа: Түрүү жил энэ тайлан гаргах дээр үл ойлголцол үүссэн. Нөгөө тайлан нь гараад ирэхээр ажлын хэсэг нь болоогүй байна гээд нөгөөдүүл нь тэгвэл мөнгөө нэмж өг гээд суучихсан шүү. Энэ жил бол тиймэрхүү зүйл гаргамааргүй байгаа юм.

Б.Эрдэнэсүрэн: Та нарын энэ хийсэн ажлыг харахад баахан тоо тавьсан хүснэгт л байна. Түүнээс учир шалтгаан, цаашид яах талаар бичсэн үнэлгээ, дүгнэлт байхгүй байна. Бас хуудсандаа дугаарлалт хийхгүй бол юм эрж олоход хэцүү юм байна.

Питер: Энэ тайлан бол зөвхөн эхний байдлаар шүү дээ. Бид ажлын 2 дахь үе дээрээ та бүхний хэлж байгаа учир шалтгааныг тодруулах, дүгнэлт зөвлөмж өгөх тал дээр илүүтэй ажиллах ёстой байгаа. Дугаарлалт хийх талаар саналыг хүлээж авлаа.

н.Галсандорж: Надад 1 санал байна. Тодруулга хийнэ гэдэг нь тайланг бараг дахин хийнэ гэсэн үг болоод байна. Иймд аудиторууд зөрүү гарч байгаа компани дээрээ очоод л тэр баримт юмыг нь шалгачихвал болдоггүй юм уу?

Питер: Бид үүнийг албан бичгээр шаардаж байгаа, шаардлагатай тохиолдолд очиж ажиллана.

Н.Дашзэвэг: Энэ ирүүлсэн тайлангуудыг харж байхад гарын үсэг зурсан албан тушаалтны нэр байхгүй байна. Үүнийг нэртэй болгох хэрэгтэй байна.

Алгаа: Ийм жижиг сажиг зүйлээр оролдохоо больё.

Б.Эрдэнэсүрэн: За өнөөдрийн хурлаас ийм зүйлүүдийг дүгнэе:

- Маягтанд орсон татвар, хураамжийн төрлүүдийн дагуу тайлангийн зөрүүг тооцъё.
- Зөрүү гарч байгаа учир шалтгаан, дүгнэлт, зөвлөмжийг харин аудиторуудаас бид хүлээж байна гэдгээ анхааруулъя.
- Мөн ил тод, зөв тайлан гаргаж байгаа компаниудыг шалгаруулж батламж гардуулж өгөх гэх мэт ажлыг зохион байгуулж ч болно шүү дээ.
- Энэ бидэнд өгсөн аудиторын мэдээллийнхээ хуудсыг нь дугаарлаж байх хэрэгтэй байна
- Тайлангийн зөрүүний талаар одоо ярьмааргүй байна, харин эцсийн тайлангийн гол сэдэв байх болно гэж бодож байна.

Питер: Бид бүхэн та бүхний саналыг хүлээн авлаа.

Ш.Цолмон: Тайлан гаргаж байгаа компаниудад батламж өгөх талаар дараагийн төслийн төсөвт суусан байгаа. Тайлан маань эцсийн байдлаараа 9-р сарын 11-нд Үндэсний зөвлөлийн хурлаар орох ёстой бөгөөд тэрнээс 7 хоногийн өмнө Ажлын хэсгээр хэлэлцэгдэх төлөвлөгөөтэй байгаа.

Н.Алгаа: Энэ аудит хийж байгаа нь санхүүгийн аудит биш ч гэсэн бас компаниудын тусын тулд ня-бо бүртгэл нь олон улсын стандартад нийцэж байгаа эсэхийг нь шалгаад зөвлөмж өгчихвөл зүгээр юм.

Питер: Бид энэ аудитыг хийхдээ ня-бо бүртгэлийн асуудал руу нь орох эрхгүй байгаа л даа. Зөвхөн төлбөр хийсэн мэдээллийг л цуглуулж байгаа.

Б.Эрдэнэсүрэн: Засгийн газрын байгууллагууд болон Ажлын алба улам идэвхтэй ажиллах хэрэгтэй. Хийсэн, хийх гэж байгаа ажлуудаа сайн сурталчилж, мэдээллийг сайн түгээх хэрэгтэй байна. Телевиз, сонингуудаар үнэ төлбөргүй сурталчлуулах талаар хөөцөлд. Хууль эрх зүйг нь судла, Ерөнхий сайдын гарын үсэгтэй бичиг ч явуулж болно шүүдээ. Засгийн газрын Хэвлэл мэдээллийн албатай хамтарч ажиллаж болно.

Шийдвэрлэсэн нь: 1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2007 оны тайланд Эрнст энд Янг Монголиа Аудит компанийн хийж байгаа аудитын I үе шатны ажлын явцыг хангалттай гэж дүгнэв.

2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2007 оны тайланд Эрнст энд Янг Монголиа Аудит компанийн хийж байгаа аудитын эцсийн тайланд ажлын хэсгийн гишүүдийн саналыг тусган гэрээнд заасан хугацаанд чанартай бэлтгэж танилцуулахыг зөвлөв.

Б.Эрдэнэсүрэн-За ингээд өнөөдрийн хурлаа өндөрлөе. Ажлын хэсгийн хуралдаанд хүрэлцэн ирсэн, санал зөвлөмж гаргасан гишүүддээ баярлалаа.

Ажлын хэсгийн хуралдаан 18 цаг 20 минутад дуусав.

Хуралдааны тэмдэглэлтэй танилцсан: Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
Ажлын хэсгийн ахлагч Б. Эрдэнэсүрэн

Хуралдааны тэмдэглэл хөтөлсөн: ОҮИТБС-ын Ажлын албаны ажилтан

Т.Хүрэлчимэг